

АВЛИГА БА МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ” дугуй ширээний ярилцлага

ИЛ ТОД БАЙДАЛ: БИД ЮУГ МЭДЭХИЙГ ХҮСЧ БАЙНА ВЭ?

Социалист нийгэм хүмүүсийн эрэлт хэрэгцээ, ашиг сонирхол, түүнийг илэрхийлж хангах суурь өжцөл болсон мэдээллийн урсгалыг хаан боогдуулж хаалттай байснаас болж сүйрсэн гэж хэлбэл нэг их хэвтрүүлэг болохгүй биз. Зүүн Европын орнуудад коммунист дэглэмийг “Америкийн дуу хоолой”, “Эржлөө” радио станцууд нураасан гэж хэлдэг. Энэ бүхэн нэгэнт түүх болжээ.

Өнөөдөр нийгмийн бүхий л институци, түүний дотор төр, бизнес, улс төрийн нам, төрийн бус байгууллагууд нээлттэй байна гэдэг бол ардчилал, зах зээл оршин тогтнох үндэс болж юм. Ардчилалд ил тод байдал ямар хэрэгтэйг бид сайн мэднэ. Зах зээлийн тухайд бусдаас иүү бараа , үйлчилгээгээр хангасан тал нь амжилт олж, бусад ньүүнийг давж гарахын төлөө чөлөөтэй өрсөлдөж үүний ачаар нийтдээ хөгжиж дэвшдэг тэр механизм саадгүй ажиллахын тулд энэхүү үйл явц дээд зэргээр нээлттэй байх учиртай. ёстой. Үнэ, ханш, чанар аас эхлээд эрэлт хэрэгцээ, нөөц баялаг, цаашилбал зах зээлд оролцогчид, тэдний эзэмшил, сонирхлын өрчлийн тухай мэдээлэл хэдийнчинээн хаалттай байна, өлөөт шударга өрсөлдөөнөөс төдийчинээн ухарч байгаа хэрэг юм.

Энэ бүх мэдээлэл нийгмийн оршин тогтнох үндэс юм бол нийгмийн баялаг гэсэн үг. Иймээс бүх нийтэд нээлттэй байх учиртай.

Ил тод байдлыг нөгөө талаас нь харвал хяналт юм. Үүнээс илүү хатуу хяналт гэж үгүй. Иргэн би өр д сонгогдоогүй, шийдвэр гаргахад оролцохгүй, хэрэглэгч би бизнесийн дотоод хэрэгт хуруугаагрдх эрхгүй байж болно, гэхдээ мэдэж, мэдээлэл авч байх нь тэдэндлөөлж байна гэс эн үг. Төрийн өндөр албан тушаалтан юмуу том олигарх өөрийг нь 2 сая гаруй хүний нүд тасралтгүй ширтэж байна гэдгийг мэдрэхээс хатуу хяналт гэж байх уу?

Ил тод байдлын үндсэн элемент гэвэл би хамгийн түрүүнд чөлөөт хэвлэл мэдээлэл, түүний илчилж эрэн сурвалжлах үйл ажиллагаа, хийж гүйцэтгэдэг бие даасан сэтгүүлчдийг хэлнэ. Дараа нь ил тод байдлыг хангадаг хууль тогтоомж, түүний дотор Авилгын эсрэг хууль, Мэдээлэл авах эрх чөлөөний хуулийг хэлнэ.

Мэдээллийн эрх чөлөөний хуулиуд юуны өмнө төрийн байгууллагад холбоотой. Харин бизнесийн байгууллагын тухай мэдээллийг төрийн зохицуулалт, хяналт шалгалтын байгууллагаар дамжуулан авах боломж байх ёстой. Эцсийн дүндээ төр, бизнесийн болон бусад байгууллага өөрөө ил тод байдаг тийм соёл манай нийгэмд хэвших ёстой.

Манай хэлэлцүүлгийн сэдэв “Авилгал ба мэдээллийн эрх чөлөө” учраас төр, бизнесийн аль алинтай холбоотойгоор ярья. Тэгээд ч сүүлийн жилүүдэд төр, бизнес хоёр маш их холилдчихоод байгаа. Олигархжсан төр гэн мэтээр ярьдаг болжээ.

Өнөөдрийн хамгийн чухал асуудал бол Оюутолгой, Тавантолгой. Дэлхийд томоохонд орох энэхүү нүүрсний ордыг үндэстэн дамнасан гэдэг шиг хоёр нам дамнасан 14 компани эзэмшчихсэн байсныг бид хэдэн жилийн дараа мэдсэн. Манай чөлөөт хэвлэл мэдээлэл, яруу алдарт сэтгүүлчид мэдээгүй байжээ. Тэдгээр компаниуд үхэн хатан нуусан байж болно, гэхдээ тэдэнд эзэмшүүлсэн төр нуулцсан байжээ.

Хөрөнгө орлогын мэдүүлэг гэж байна. Жил бүрийн 2-р сарын 15-ны дотор төрийн албан хаагчид мэдүүлгээ өгч хэсэг хугацааны дараа Авлагатай тэмцэх газраас

төрийн өндөр албан тушаалтнуудын хөрөнгө орлогын хураангуйлсан мэдээллийг олон нийтэд зарладаг. Жишээлбэл, УИХ-ын гишүүн тийм компанийн 3000 хувьцаа эзэшдэг гэж бичсэн байвал энэ нь хувьцааны тоог бичээгүйтэй яг адилхан. Яагаад гэвэл 1 сая хувьцааны 3000 юмуу, 6000 хувьцааны 3000 уу гэдэг нь тодорхойгүй. Авилгатай тэмцэх газар төрийн албан хаагчдаас тусгай анкетаар нэлээд дэлгэрэнгүй мэдээлэл авдаг байх, гэхдээ нарийвчилсан мэдээллийг аваад үлдчихдэг. Энэ нь хэдэн жилийн өмнө УИХ-ын гишүүдийн орлогын мэдүүлгийг авдаг мөртлөө УИХ-ын Тамгын газрын даргын сейфэнд хадгалдаг байсныг санагдуулдаг.

Олон нийт, хэвлэл мэдээллийнхэнд хэдийчинээ их мэдээллийг өгнө, олон нийтийн хяналт төдийчинээн чанга байхсан.

Би яагаад мөнгө хөрөнгө яриад байна вэ? Сэтгүүл зүйн алтан дүрэм байдаг: Илрүүлье, илчилье, эрэн сурвалжлая гэвэл мөнгөний мөрөөр хөө. Өнөөдөр төр, бизнес хоёр нэг болсон учраас аль яг таарч байгаа юм.

Энгийн асуулт. Монголын ард түмний эв нэгдлийн баталгаа болсон, энэ утгаараа үлгэр дууриал болох учиртай Ерөнхийлөгчийнхөө өмч хөрөнгийг мэдэж байгаа юм уу?

Би нэгэн түүх ярья.

2003-2004 оны үед Төрийн ордонд болсон семинар дээр би Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд байсан Ц.Мөнх-Оргилд хандаж, тэр үед шинээр мэндэлсэн TV9 телевизийн үүсгэн байгуулагчид хэн бэ? гэсэн асуултыг тавьж билээ. Тэр үед ХЗДХЯ иргэдийн тавьсан асуултанд шууд хариулдаг дүрэм журам гаргасан гээд магтагдаж байсан үе. Сайд хэлэхдээ “манайд олон хэвлэл мэдээлэл бүртгүүлдэг болохоор би сайн санахгүй байна. Та манайд албан бичгээр тавиад хариу ав гэсэн. Хэд хоногийн дараа хэлтсийн дарга нь “Дуламсүрэн” гэж нэр хэлж элсэн өгсөн.

Хоёр жилийн дараа Ерөнхийлөгч Н.Энхбаяр ярилцлага өгч, Мөнх-Оргил надад суваг байна, хамтраад телевиз байгуулья гэсэн санал тавьсан, тэгээд Японы шашны байгууллагаас бэлэглэсэн тоног төхөөрөмжтэй нийлүүлээд TV9-ыг төрүүлсэн тухайгаа зарласан билээ.

Одоо “Зууны мэдээ”-г Ерөнхийлөгчийн сонин гэж бүгд ярьдаг. Гэтэл Ерөнхийлөгчийн юмуу түүний хэвлэл мэдээллийн албаны зүгээс таг дуугүй. Магадгүй Ерөнхийлөгч маань Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа сэтгэлээ онгойлгож ярих биз.

Төрийн ордны зүүн талд хэдэн жилийн турш балгасын төрхийг олоод байгаа Улсын хэвлэлийн комбинатын түүхт барилгыг Ерөнхийлөгчийнх гэдэг. Үүнд, яагаад хариу өгөхгүй байна вэ? Энэ бол манай төрийн өндөр дээр албан тушаалтнууд хэр нээлттэйг харуулсан жишээ. Өөрчлөлт шинэчлэлийг өөрөөсөө эхлээ гэдэгсэн.

Хэрвээ төрийн байгууллагууд, төрийн албан тушаалтнуудаас мэдээллийн ил тод байдлыг нэхвэл тэд хэлэх үгтэй. Төр засгийн мэдээлэл үнэхээр хангалттай байгаа. Телевизийн оройн мэдээллийн хөтөлбөрийн ихэнх нь официоз буюу төрийн ордон, яам агентлагт болсон үйл явдал, хурал зөвлөгөөн, уулзалт, албан тушаалтнуудын яриа, тайлбар. Студид болдог ток шоунаас эхлээд хоол унд хийх нэвтрүүлэгт төрийн албан хаагчид тасрахгүй. Манайх шиг ард түмэндээ ойр, нээлттэй төр байдаггүй байх гэмээр.

Өнөөдөр мэдээллийг цацах шиг амархан юм байхгүй. Аливаа мэдээллийг хувилах, олшруулах зардал тэг болсон гэхэд хилсдэхгүй. Copy-paste, эсвэл каноны start гэсэн команд өгөөд гүйцээ. Мэдээллийг түгээхдээ Send гэсэн цэсэн дээр дарах, эсвэл хэдхэн үйлдэл хийгээд вэб сайтад байршуулахад хангалттай. Хэрвээ ингэх хэцүү санагдвал хэвлэлийн хурал зарлахад арван хэдэн телевиз,

арван хэдэн өдөр тутмын сонин гүйгээд ирнэ. Нээлттэй байхыг хүссэн төр засагт өөр юу хэрэгтэй юм бэ?

Энэ бүх бизнесийн болоод бусад байгууллагад ч хамаатай. Зөвхөн компани байгууллагын ой, шинэ дэлгүүр, салбарын нээлт биш, тендер, хөрөнгө оруулалт, ашиг орлогоо тайлагнадаг, жилийн тайлангаа танилцуулдаг баймаар. Сүүлийн үед модонд орсон компанийн нийгмийн хариуцлага гэдэгт төдөн төгрөгийн хандив тусламж үзүүлсэн тухай PR биш, чухам дээрх нээлттэй байдлыг хамгийн түрүүнд багтаамаар санагдаж байна.

Хэвлэл мэдээллээр дүүрэн төрийн албан тушаалтнууд болон эзэд захирлуудын ярилцлагууд байна. Төрийн нөр их ажил алба, бизнесийнхээ талаар ярихдаа хувийн амьдралаа сайн дэлгэдэг. Хаана төрж ямар цэцэрлэг сургуульд явж байсан, хэн хэнтэй хамт сурсан, нэг удаа ямар сонин үйл явдал тохиолдсон, эхнэртэйгээ яаж танилцсан, цаашаагаа хурдан моринд дуртай эсэх, ямар хоол хийдэг...

Нэг үгээр хэлбэл, мэдээллээр булчихдаг. Тэнд миний дээр хэлсэн мэдээлэл байдаггүй. Заримдаа хэрэгтэй мэдээлэл ганц ч байхгүй. Будаатай хуурга сайн хийгээ л биз, тэгээд юу гэж?

АНУ-д Конгрессын гишүүн юм уу, Худалдааны яамны сайд ийм ярилцлага өгдөг болов уу? Хамгийн гол нь тэдэнд ийм асуулт тавьдаг болов уу? Үгүй байх. Тэнд төрийн албан тушаалтнууд зүгээр л ажил хийдэг, манайхан шиг төрд алба хашиж чөмгөө дундрууллаа гэж одон медаль нэхээд явдаггүй болов уу. Харин хууль зөрчсөн, сонирхлын зөрчилд автсан тохиолдолд олон нийтийн анхааралд шууд өртдөг. Манайд эсрэгээр, өндөр албан тушаалд суусан л бол шууд од болж хувирдаг. Олон нийт ч гэсэн тэднийг шоу болгож харсаар байгаад үүрэг, хариуцлага нэхэхээ мартаад байх шиг. Саяхан УНДЕГ-ын дарга асан С.Эрдэнэ нар мөнгө төгрөг идэж уучихсаныг, бас сонгуулийн дүнг будлиулсныг хууль хяналтын байгууллага олж тогтоосон тэр баримтыг олон нийт ч, хэвлэл мэдээлэл дурдахаас хэтрэхгүй байна. Тэр ч бүү хэл олон нийтийн лав тэн хагас тэднийг өмөөрөх хандлагатай байгааг гудамжинд яваа хүмүүсийн телевизэд өгсөн яриа, Интернэтэд тавигдсан сэтгэгдлээс харж болно.

Манай хэвлэл мэдээлэл үйл явцыг дагаад байх юм. Ямар нэгэн асуудлыг нийтийн эрх ашиг, шударга өрсөлдөөний зарчим, хууль ёсыг сахиж, буруутай этгээдүүдийг шийтгэж оновчтой шийдвэр гаргаж, тэгээд зөв зохион байгуулаад шийдэж болно. Эсвэл эцэс төгсгөлгүй тогтоол шийдвэр, хурал семинар, аян хөтөлбөр зохиогоод, бас ингэх тэгэх ёстой гэж мэдэмхийрсэн ярилцлага, тайлбар өгөөд явж болно. Манай хэвлэл мэдээлэл хоёрдахийг нь хөөгөөд дэвэргээд байх юм. Чингэлтэй дүүрэгт айл өрхүүдэд гэр олгосон үйл явдал болжээ. Энд нийслэл, дүүргийн засаг дарга албан тушаалтнууд, тус дүүргээс сонгогдсон УИХ, дүүргийн хурлын төлөөлөгчид, яамны сайд дарга нар, зарим байгууллагын дарга нар оролцдог. Дараа нь дээрх албан тушаалтнууд болон яам, байгууллагын тайланд хийсэн ажил болж орно. Нэг ажил 10 дахин үржигдэнэ. Тэгээд энэ тайлангаараа хэвлэл мэдээлэл, олон нийтийг булна. Ойд орсон модыг олж хардаг, гэхдээ ойгоо харахаа больдогтой нэгэн адил. Үр дүн юу болох вэ гэвэл тэр хэдэн гэр айлын хашаанд баригдаж Улаанбаатарын утаа тэр хэмжээгээр нэмэгддэг.

Үйл явдлын өрнөлийг мэдэж байх хэрэгтэй, гэхдээ түүний жинхэнэ утга учир, үнэ цэнэ, үр дүн илүү чухал. Аливаа зах зух, сураг ажиг, таамаглал, маргаан, хэлэлцүүлэг чухал, гэхдээ жинхэнэ баримт, бодит үнэн, бүрэн дүүрэн мэдээлэлд хүргэдэг буюу ойртуулдаг байх ёстой. 7-р сарын 1-ны үйл явдлаас хойш хагас жил өнгөрсөн ч үймээнд самуунд оролцсон хүмүүсийг шорон руу илгээгээд байгаа болохоос биш, тэр үйл явдлын эхлэл ба төгсгөлтэй холбоотой мэдээлэл үндсэндээ хаалттай, гол оролцогчид нь мөрдөн байцаалтын нууцыг задлах эрхгүй, ингээд нийгэмд бодитой мэдээлэл алга хэвээрээ байна. Улс төрийн намуудын санхүүжилт, тухайлбал, намдаа хандив өргөсөн гаалын Баатарын

хэргээс эхлээд 2008 оны УИХ-ын сонгуулийн санхүүжилтын мэдээлэл хагас жил өнгөрчихөөд байхад олон нийтэд дэлгэгдээгүй байна.

Уг нь цэцэглэн хөгжиж байгаа үй олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл зүйрлэж хэлбэл төр, бизнес, байгууллагуудыг “бариад идчихмээр”. Тэгэхгүй байна.

Хэрэгтэй мэдээлэл, хэрэгтэй цагтаа, хэрэгтэй хүндээ нээлттэй байх ёстой. Чухам үүний тулд иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн зүгээс мэдээлэл авах эрх чөлөөний тухай хуулийг нэхэж байгаа. Төрийн болон төрийн байгууллагаар дамжуулан бизнес, улс төрийн намууд, байгууллагын мэдээллийг нээлттэй болгох тухай ярьж байна.

Өнөөдөр “манайх вэб сайттай” гэдэг бол “мэдэхгүй мянган үгний таглаа” болоод байна. Уг нь маш зөв. Ил тод байдлыг хангахад Интернэт агуу боломжийг нээж байна. Монгол Улсын ерөнхийлөгч, УИХ-аас эхлээд яам, агентлаг, улс төрийн намууд, компани, байгууллагууд вэб сайттай болж байна. Улс төрчдийн хувийн вэб сайт, блогууд олширлоо. Би 2008 оны 4-р сард сонирхож үзэхэд www.bayar.mn, www.batbold.mn, www.elbegdorj.mn домэй нэрийг аваагүй байсан бол сонгуулийн үеэр үзэхэд бүгд эзэнтэй болсон.

Дээрх вэб сайтуудад тухайн байгууллагын бүх мэдээлэл байгаа, үүнд байгууллагын танилцуулга, даргын зурагтай мэндчилгээнээс эхлээд ажлын тайлан, журам дүрэм байдаг. Энэ бүхэн сайн хэрэг, гэхдээ олон нийт, хэвлэл мэдээллийнхэнд хэрэгтэй мэдээлэл, хэрэгтэй цагтаа алга. Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчилж өөрсдийгөө “зөвөөр” харуулахын төлөө байдаг нь мэдээж. Өөрөөр хэлбэл сонирхлын зөрчилтэй. 2000-2004 онд Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанаас “Баттай мэдээлэл” нэртэй сайт ажиллуулж байсныг санаж байна.

Чухам иймээс мэдээллийн урсгал, нээлттэй байдлыг хангадаг нийгмийн тусдаа институт – олон нийтийн мэдээллийн хэрэгсэл байдаг билээ.

Одоо УИХ-ын хэвлэл мэдээллийн алба өргөжиж Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны хэлтэс болсон гэж байна. Нэрийг нь анзаараарай. Олон нийттэй харилцах барих яасан бэ? Улаанбаатар хот бол ил тод байдлын салхи огт ороогүй байсан газар, Саяхнаас сэвэлзаж магадгүй байгаа. Гэтэл нийслэл, дүүргүүд хэвлэл мэдээллийн албаа бэхжүүлэхийн оронд Засаг даргын мөрийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтний орон тоо бий болгожээ. Одоо зогсоо зайгүй тайлан үйлдвэрлэж түүнийгээ сурталчилж гарахнээ. Нийслэл маш их ажил хийдэг боловч сурталчлахгүй, иймээс иргэд мэдэхгүй шүүмжлээд байна гэж ярихыг хотын дарга нарын амнаас би хэд хэдэн удаа сонсож байсан. УИХ, Засгийн газар ч гэсэн мөн адил. Оны өмнөхөн тэмдэглэж өнгөрүүлсэн Засгийн газрын 100 дахь хоног хэмээх арга хэмжээг би зүгээр л хайран хөрөнгө мөнгө үрсэн сурталчилгаа гэж хэлнэ.

Ноднин Улаанбаатар хотын төсөв, өмчийн холбогдолтой асуудлаар Иргэний холбооноос 5 удаа бичиг явуулахад хариу өгөөгүй. Нийслэлийн ИТХ-аас Иргэний холбооны асуулгад хариу өгөх ажлын хэсгийг байгуулж сүржингэсэн байсан. Уг нь зүгээр л мэдээлэл өгчихөд хангалттай байхад шүү.

Тэд хамтарч хуралдах, ажлын хэсэг комисс байгуулах, төлөвлөгөө гаргахыг бол зөвшөөрөөд байдаг, харин мэдээллийг огт өгдөггүй. Хоёр жилийн өмнө “Үндэсний соёмбо” хөдөлгөөн зэрэг иргэний байгууллагууд 1996 оноос хойшхи Нийслэлийн Засаг даргын шийдвэр захирамжтай танилцья гэсэн хүсэлт тавьсан нь мөрөөдөл байжээ. “Улаанбаатар” сангаас мэдээлэл авахыг хүссэн “Хүний эрх хөгжил” төвийн албан бичигт “өгөх шаардлагагүй” гэсэн хариулт өгч байсан гэдэг. Нийслэлийн Засаг даргын хэдэн жилийн өмнөх захирамжийг шүүхийг журмаар гаргуулж авахад нэг захирамжинд багтсан бусад газрын зөвшөөрлийг зориудаар нугалж далдлаад хуулж өгсөн байдаг.

Энэ бүгдэд хэн буруутай. вэ? Талд нь төр өөрөө, талд нь хэвлэл мэдээлэл буруутай гэж би хэлнэ. Гэхдээ энэ бол тусдаа ярих сэдэв юм.

Өнгөрсөн жилүүдэд бид мэдээлэл авах эрх чөлөөний хуульгүй яваад ардчилал, зах зээлийн шидэт гар зохицуулж өгсөнгүй. Тэгэхлээр одоо хуультай болох, түүгээрээ балбаж байгаад ил тод байдлыг төр, бизнес, олон нийтийн амьдралын хэм хэмжээ, соёл болгох учиртай.

**Д.Цэрэнжав (Ил тод байдал сан)
2009.01.30.**